

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



20 25 оны 03 сарын 05 өдөр

№ R-2025-06

Улаанбаатар хот

Холбогдох этгээдийн болон сонирхлын
зөрчилтэй хэлцлийг батламжлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-48 дугаар тогтоолоор батлагдсан Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журмын 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Банкны ТУЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ") нь 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлаараа гаргасан шийдвэрийн үр дүнд, Банкны эрх бүхий албан тушаалтнуудын холбогдох этгээдүүдэд олгосон, энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөл бүхий нийт 66,800,000 (жаран зургаан сая найман зуун мянга) төгрөгийн үнийн дүнтэй 4 хэлцлүүд ("Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд")-ийг батламжлах саналыг ТУЗ-д хүргүүлснийг;
2. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд нь аливаа хөнгөлөлттэй нөхцөлгүй, банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд харилцагчдад санал болгож буй ердийн нөхцөлөөс давуу тал олгоогүй болохыг ЭУХ тодорхойлсон болохыг; мөн
3. ТУЗ нь ЭУХ-ноос санал болгосны дагуу батламжлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хавсралт ёсоор батламжилсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

Огноо/Date



ХАСБАНК ХК

Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батламжилсан талаарх мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000239852 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00ХАС05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-мэйл: info@хасбанк.mn Вэбсайт: www.хасбанк.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Н.Цэлмэгшиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцэл батламжилсан талаарх мэдээлэл	
<p>ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2025-06 тоот тогтоолоор, Банкны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу, Банкны эрх бүхий албан тушаалтнуудын холбогдох этгээдүүдтэй байгуулсан нийт 66,800,000.00 (жаран зургаан сая найман зуун мянга) төгрөгийн үнийн дүн бүхий 4 (дөрөв) хэлцлийг батламжилсан болно. Энэхүү хэлцлүүд нь Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд олгогдсон, гуравдагч этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг хангасан болно.</p>	

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Н.Цэлмэгхишиг

Албан тушаал: ТУЗ-ийн ажлын албаны хуульч

Гарын үсэг:



Хянасан: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Огноо: 2025 он 03 сар 06 өдөр